



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

「 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
талаар хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах,
бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Улсын Онцгой комиссын “Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөө, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168 дугаар захирамжуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг байгууллагын холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

1.1 Нийслэлд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн НЗЗ-ны байруудад байрлах нутгийн захиргааны байгууллагууд, түүнд ажиллах төрийн албан хаагчид болон иргэдэд үйлчилгээ үзүүлэх НҮНТөвүүдэд халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Ашиглалт хариуцсан орлогч дарга, Үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Зоогийн үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга нарт ;

1.2 Байгууллагын гадна орчны 50м болон дотоод орчны нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөнүүдэд их цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийг хийлгэх хуваарь гарган хэрэгжүүлж ажиллахыг Зоогийн үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Үйлчилгээ хариуцсан орлогч дарга, байр хариуцсан менежерүүдэд ;

1.3 Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотойгоор байгууллагын гамшгийн төлөвлөгөөг ажилтан, албан хаагчдад танилцуулах, зарлан мэдээлэх схемийг дотоод удирдлагын UB ERP системд байршуулан, мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Ашиглалт хариуцсан орлогч дарга, Байр ашиглалтын албаны дарга нарт ;

1.4 НЗЗ-ны байрууд болон хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж, ажиллагсдад амны хаалт зүүж, гараа тогтмол ариутгаж ажиллах талаар зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Үйлчилгээний албаны дарга нарт;

1.5 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчид болон иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор амны хаалт зүүж үйлчлүүлэх

шаардлагыг тавьж хэвшүүлэх, биеийн халууныг хэмжигч төхөөрөмжийг тогтмол ашиглаж, бүртгэлжүүлж ажиллахыг Үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Үйлчилгээний албаны дарга, байр хариуцсан менежерүүдэд ;

2. Энэхүү тушаалд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

1150500093